



МОНГОЛБАНКНЫ ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТУШААЛ

2018 оны 08 сарын 02 өдөр

Дугаар A - 211

Улаанбаатар хот

Журамд өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх заалт, 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.1 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны А-151 дүгээр тушаалаар батлагдсан “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын дараах хэсэг заалт, дэд заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1) 2.3 дахь хэсгийн 2.3.2 дахь заалт:

“2.3.2. Банкны хувьцааны эцсийн өмчлөгч, түүний холбогдох этгээд, харилцан хамаарал болон нэгдмэл сонирхолтой этгээдийг тодорхойлсон бүртгэлийг холбогдох баримт бичгийн хамт Монголбанкинд мэдээлэх”;

2) 3.5 дахь хэсгийн 3.5.1 дэх заалт:

“3.5.1. ТУЗ-ийн гишүүн, түүний холбогдох этгээдийн тухайн банкнаас авсан зээл, зээлтэй адилтган тооцох актив, баталгаа, батлан даалтаар хүлээсэн аливаа үүрэг, өр төлбөрийн ангилал Монголбанкнаас тогтоосон журмын дагуу анхаарал хандуулах болон чанаргүй болсон бол тохиолдолд уг гишүүнийг банкны удирдах үйл ажиллагаанд оролцуулах”;

3) 3.5.2 дахь заалтын 3.5.2.1, 3.5.2.2 дахь дэд заалт:

“3.5.2.1. Аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хорооны гишүүн байх;

3.5.2.2. Гүйцэтгэх захирлыг сонгох, томилох, чөлөөлөх, түүний бүрэн эрхийг тогтоох, хяналт тавихтай холбоотой асуудлаар шийдвэр гаргахад саналын эрхтэй оролцох”;

4) 6.6 дахь хэсэг:

“6.6. Эрсдэлийн удирдлагын нэгж нь учирч болох эрсдэлийг банкны нэгдэл, салбар нэгж, үйл ажиллагааны чиглэл, бүтээгдэхүүн, үйлчилгээ тус бүрээр болон нэгдсэн байдлаар тогтоож, дүн шинжилгээ хийнэ”;

5) 8.1 дэх хэсгийн 8.1.3 дахь заалт:

“8.1.3. Банкны толгой компани, банкны нэгдлийн бусад оролцогч компани, тэдгээрийн үйл ажиллагааны талаар”.

2. “Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын 3.5.1 дэх заалтын “chanargүйд ангилагдсан” гэснийг “анхаарал хандуулах болон чанаргүй болсон” гэж өөрчилсүгэй.

3.“Банкны зохистой засаглалын зарчмыг хэрэгжүүлэх журам”-ын 3.4.5 дахь заалтын “улирал бүр” гэснийг хассугай.

4.Энэ тушаалыг 2018 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

5.Банкны тухай хууль тогтоомж, энэ тушаалтай нийцүүлэн банкны зохистой засаглалын бодлого, журмыг тогтоон, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг банкуудын Төлөөлөн удирдах зөвлөлд даалгасугай.

6.Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Н.Батсайхан)-т үүрэг болгосугай.

МОНГОЛБАНКНЫ
ЕРӨНХИЙЛӨГЧ



Н.БАЯРТСАЙХАН